

Монголын мэргэшсэн
үнэлгээчдийн институтын бүх
гишүүдийн 2018 оны ... дугаар
сарын ...-ны өдрийн хурлаар
хэлэлцэж батлав.

МОНГОЛЫН МЭРГЭШСЭН ҮНЭЛГЭЭЧДИЙН ИНСТИТУТИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт /цаашид институт гэх/ нь Монгол улсын мэргэшсэн /тусгай зөвшөөрөл бүхий/ үнэлгээчид, бусад дэмжигч иргэн, байгууллагыг сайн дурын үндсэн дээр эгнээндээ нэгтгэсэн, гишүүддээ болон нийгэмд үйлчилдэг, хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн, төрийн бус байгууллага мөн.

1.2 Институт нь үйл ажиллагаагаа Монгол улсын Хөрөнгийн үнэлгээний болон Төрийн бус байгууллагын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ хэлэлцээр, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомж болон энэ дүрмийн шаардлагад нийцүүлэн явуулна.

1.3 Институт нь Монгол улсад үнэлгээний үйл ажиллагааг төлөвшүүлэх, үнэлгээний үндэсний стандартыг боловсруулж мөрдүүлэх болон үнэлгээчид, үнэлгээний байгууллагуудын эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн ёс зүйн дүрмийг чанд сахиулах, үнэлгээний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, гишүүдийг мэдээллээр хангах, тэдний мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэхэд туслалцаа үзүүлэх, үнэлгээний ажлын чанарт хяналт тавих, дотоод, гадаад харилцааг хөгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

1.4 Институт нь олон улсын болон бүс нутгийн мэргэжлийн байгууллагын гишүүнчлэлтэй байж болно.

1.5 Институтийг монгол хэлээр “Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт”, товчлол нь “ММУИ”, англи хэлээр “Mongolian Institute of certified Appraisers”, товчлол нь “MICA” гэсэн оноосон нэрээр нэрлэнэ.

1.6 Институт нь өөрийн далбаа, бэлгэ тэмдэг, харилцах данс, тамга тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх ба өөрийн хэвлэлтэй байж болно.

1.7 Институтийн төв байр нь Улаанбаатар хотод байрлана.

Хоёр. Үйл ажиллагааны зарчим

2.1 Институт нь үйл ажиллагаандаа хуулийг дээдлэх, ил тод байдал, ардчилсан ёс, үндсэн асуудлаа хамтран шийдвэрлэж, гаргасан шийдвэрийг институтийн гишүүн бүр биелүүлэх зарчмыг хэрэгжүүлнэ.

2.2 Институтийн үйл ажиллагаа аливаа нам, бүлэглэл, улс төр, шашны байгууллагын үйл ажиллагаанаас ангид байж, хараат бус, шударга, нээлттэй байх зарчимд тулгуурлана.

ТӨСӨЛ

2.3 Институтийн гишүүн нь үйл ажиллагаандаа төрийн хуулийг дээдлэн, энэхүү дүрэм болон үнэлгээчдийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг чанд баримтална.

2.4 Институт нь үнэлгээний үйл ажиллагааг арга зүйн удирдлагаар хангах замаар Монгол улсад өмчийн үнэлгээний нэгдмэл байдлыг бий болгож, төлөвшүүлэн хөгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

Гурав. Институтын зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл

3.1. Институтын үйл ажиллагааны эрхэм зорилго нь:

3.1.1. Үнэлгээний бодит байдал, үнэлгээчдийн ёс зүй, ур чадвар, хараат бус байдлыг хангах замаар нийтийн ашиг сонирхолыг хамгаалах;

3.1.2. Үнэлгээний мэргэжлийн тогтвортой өсөлт хөгжлийг хангах;

3.1.3. Үнэлгээг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, чадварлаг үйлчилгээг үзүүлснээр олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөх;

3.1.4 Мэргэшсэн үнэлгээчид, үнэлгээний байгууллагуудын удирдлага, зохион байгуулалтын нэгдмэл байдлыг хангах.

3.1.5 Үндэсний үнэлгээний үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх.

(өөрчлөн найруулж, тусад нь заалт болгож өөрчилсөн)

3.2. Институт нь Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагад хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлж, дараах үйл ажиллагаа явуулна. Үүнд:

3.2.1 Үнэлгээчдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, мэдээллээр хангах;

3.2.2 ҮОУС-ыг орчуулах, үндэсний зарим стандарт, заавар журам боловсруулж, хэлэлцүүлэг хийж, батлаж, мөрдүүлэх;

3.2.3 Институтээс мэргэшсэн үнэлгээчдийн ёс зүйн дүрмийг Үнэлгээний олон улсын стандарт (ҮОУС)-д нийцүүлэн боловсруулж батлах, мөрдүүлэх, түүний биелэлтэд хяналт тавьж ажиллах;

3.2.4 Үнэлгээний мэдээллийн сан бүрдүүлж гишүүдэд ашиглуулах;

3.2.5 Үнэлгээний гишүүн байгууллага, үнэлгээчний үйл ажиллагааны нэгдсэн мэдээлэл бий болгох;

3.2.6 Хөрөнгийн үнэлгээний тухай болон бусад хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх талаар санал боловсруулах, үнэлгээтэй холбоотой асуудлаар бусад байгууллагаас шинээр гаргах, өөрчлөх хууль, дүрэм, журамд санал өгөх;

3.2.7 Үнэлгээчдийг бэлтгэх, давтан сургах, үнэлгээчдийн мэргэжлийн тасралтгүй болон нийтийн боловсролын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

(найруулгаар өөрчлөгдсөн)

ТӨСӨЛ

3.2.8 Хөрөнгийн үнэлгээний асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах;

3.2.9 Төрийн захиргааны холбогдох байгууллагатай хамтран мэргэшсэн үнэлгээчдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;

3.2.10 Үнэлгээний ажлын чанарт хяналт тавьж ажиллах;

3.2.11 Гишүүн байгууллага, үнэлгээчдийн мэргэжлийн ашиг, сонирхлыг хамгаалах;

3.2.12 Мэдээлэл, сурталчилгааны ажлыг хуулийн хүрээнд явуулах;

3.2.13 Үнэлгээний үйл ажиллагааны цар хүрээ, гишүүдийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг эрж хайх, тэдний нийтлэг эрх ашигт холбогдох асуудлыг төрийн захиргааны болон холбогдох бусад байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.2.14. Олон улсын болон бүс нутгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагуудад гишүүнээр элсэж, гадаад улс орнуудын үнэлгээний мэргэжлийн байгууллагуудтай сайн харилцааг бий болгох, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

(найруулгаар өөрчлөгдсөн)

3.2.15. Засгийн газар, төрийн болон төрийн бус байгууллагуудтай сайн харилцааг бий болгох, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

(найруулгаар өөрчлөгдсөн)

3.2.16. Үнэлгээчдийг сонгон шалгаруулах журмыг институтээс төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн хамтран боловсруулж мөрдөнө.

Дөрөв. Институтийн гишүүнчлэл

4.1 Институт нь гишүүнээр элсүүлэх, гишүүдэд ангилал, зэрэглэл тогтоох, гишүүнээс чөлөөлөх, хөнгөлөх, түтгэлзүүлэх журмыг Удирдах Зөвлөлөөр батлуулан мөрдөнө.

(найруулгаар өөрчлөгдсөн)

4.2. Институтын гишүүнчлэл нь дараахь төрөлтэй байна.

(найруулгаар өөрчлөгдсөн)

4.2.1. Хөрөнгийн үнэлгээний холбогдох сургалтад хамрагдан, үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан үнэлгээчид нь энэхүү дүрэм болон ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрснөөр институтийн гишүүн болно;

4.2.2. Хүндэт гишүүн, ахмад гишүүнтэй байна;

(нэмэгдсэн)

4.2.3. Үнэлгээчний туслах (дадлагажигч), оюутан, суралцагчид институтийн дүрмийг хүлээн зөвшөөрснөөр институтийн гишүүнээр элсэж болно;

(нэмэлт өөрчлөгдсөн)

4.2.4. Үнэлгээний компаниуд;

ТӨСӨЛ

4.2.5. Төрөлжсөн холбоо болон үл хөдлөх хөрөнгийн арилжаа зуучлал, зөвлөгөө өгөх үйлчилгээг эрхэлдэг байгууллага, сургалт эрдэм шинжилгээний байгууллага болон үнэлгээний үйл ажиллагаанд оролцох сонирхолтой бусад гадаад, дотоодын хуулийн этгээд гишүүнээр элсэж болно.

(найруулгаар өөрчлөгдсөн)

4.3. Дүрмийн 4.2.1-д зааснаас бусад гишүүд саналын эрхгүй байна.

(найруулгаар өөрчлөгдсөн)

4.4. Хуулийн этгээдийн гишүүнчлэл нь тэнд ажиллаж байгаа үнэлгээчдийн гишүүнчлэлийг орлохгүй.

(найруулгаар өөрчлөгдсөн)

4.5. Үнэлгээний компани дараах шаардлагыг хангасан байна.

4.5.1. Тусгай зөвшөөрөл бүхий үндсэн орон тооны 2 ба түүнээс дээш үнэлгээчинтэй байх;

4.5.2. Компанийн захирал нь үндсэн орон тоогоор ажилладаг, үнэлгээчин байх;

4.5.3. Ажлын байртай байна.

(нэмэгдсэн)

4.6 Дараахь тохиолдолд гишүүнчлэлээс хасна:

4.6.1. Удирдах Зөвлөлийн шийдвэрээр

4.6.2. Гишүүн үнэлгээчний болон гишүүн компанийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болсон бол.

(нэмэгдсэн)

Тав. Гишүүний эрх, үүрэг

5.1 Гишүүний эрх

5.1.1 Институтийн дүрэм, үнэлгээний үйл ажиллагаатай холбоотой бодлого шийдвэр, аргачлал, журам боловсруулах, хэлэлцэж батлахад оролцох, санал шүүмжлэл чөлөөтэй гаргах;

5.1.2 Институтээс мэргэжлийн холбогдолтой мэдээлэл авах, сургалтад хамрагдах, эдгээр асуудлаар шаардлага тавих;

5.1.3 Эрхээ хамгаалуулах асуудлаар институтэд хандан санал хүсэлт гаргах, институтийг үүргээ гүйцэтгэх талаар шаардлага тавих;

5.1.4 Тусгай зөвшөөрөлтэй үнэлгээчин нь бүх шатны сонгуульд сонгох, сонгогдох;

5.1.5 Институтийн гишүүд нь өөрийн хүсэлтээр гишүүнчлэлээс гарах.

(өөрчлөгдсөн)

ТӨСӨЛ

5.2 Гишүүний үүрэг

5.2.1 Институтийн дүрэм, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд санаачлагатай оролцох;

5.2.2 Институтээс зохион байгуулж байгаа төлөвлөгөөт сургалт, уулзалт ярилцлагад оролцож мэргэжил, туршлагаа байнга дээшлүүлэх;

5.2.3 Институтэд санхүүгийн талаар дэмжлэг үзүүлж, татвар төлөх;

5.2.4 Эрхэлсэн ажил, албан тушаал, харъяалал, хаягийн өөрчлөлтөө бүртгүүлж байх;

5.2.5 **Гишүүн үнэлгээчид** институтийн болон үнэлгээчний ёс зүйн дүрмийг чанд биелүүлэх;

(тодруулга өөрчлөлт оруулсан)

5.2.6 **Гишүүн үнэлгээчид** институтэд үйл ажиллагааныхаа жил тутмын тайланг өгч, нэгдсэн судалгаа болон үнэлгээний мэдээллийн санг бүрдүүлэхэд **оролцох**;

(тодруулга өөрчлөлт оруулсан)

5.2.7 **Гишүүн үнэлгээчид** хөрөнгийн үнэлгээний хуульд заасны дагуу үнэлгээчний хариуцлагын даатгалд заавал даатгуулах;

(тодруулга өөрчлөлт оруулсан)

5.2.8 Үйл ажиллагаагаа хөрөнгийн үнэлгээний болон бусад хууль тогтоомжийн хүрээнд явуулах болон хуульд заасан бусад үүрэг;

5.2.9 Хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрөл бүхий үнэлгээчид дангаараа болон нэгдэж үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх компани байгуулсан тухайгаа институтэд бүртгүүлэх үүрэгтэй.

(тодруулга өөрчлөлт оруулсан)

Зургаа. Гишүүдийн элсэлтийн хураамж, татвар

6.1 Институтийн гишүүн байгууллага, гишүүд элсэлтийн хураамжийг анх гишүүнээр элсэхэд нэг удаа, гишүүний татварыг жил тутам төлнө.

6.2. Гишүүний татвар, элсэлтийн хураамж:

6.2.1. Элсэлтийн хураамж энэхүү дүрмийн 4.2.4-4.2.5-т заасан гишүүн байгууллага 500 000 төгрөг, дүрмийн 4.2.1, 4.2.3 хувь хүн 50,000 төгрөг;

6.2.2. Гишүүний нэг жилийн татвар нь 4.2.1-т заасан үнэлгээчин 200,000 төгрөг, төрийн байгууллагын ажилтан 80,000 төгрөг, 4.2.4-4.2.5-т заасан байгууллага 500,000 төгрөг, үнэлгээчний туслах 60,000 төгрөг байна.

*(элсэлтийн хураамж, татвар нэг заалт байсныг салгаж өөрчилсөн.
дүнд өөрчлөлт ороогүй)*

6.2.3. Дүрмийн 4.2.2-т заасан гишүүн, оюутан, суралцагчид татвар төлөхгүй.

(нэмэгдсэн)

төсөл

6.3 Гишүүд нь татвараа тухайн оны 2-р сарын 10-ны дотор төлж, тооцоо хийнэ.

Долоо. Институтийн бүтэц

7.1 Институт нь үнэлгээний чиглэлээр төрөлжсөн холбоодыг нэгтгэсэн, үйл ажиллагааны хувьд нэгдсэн хэлбэртэй байна.

7.2 Институтийн төрөлжсөн холбоо, хөрөнгийн үнэлгээний консорциум зэрэг мэргэжлийн болон үүсгэл санаачлагын байгууллага нь институтын үйл ажиллагааг төлөөлөхгүй.

7.3 Институт нь орон нутагт төлөөлөгчийн газар (салбар)-тай байж болно.

7.4 Институт нь дүрмийн шаардлагыг хангах зорилгоор төрөлжсөн холбоо, ажлын хороо, шаардлагатай бусад нэгж байгуулан ажиллаж болно.

7.5 Институтийн зохион байгуулалтын бүтэц нь бүх гишүүдийн хурал, удирдах зөвлөл, тэргүүн, гүйцэтгэх удирдлага, түүний ажлын албанаас бүрдэнэ.

7.6 Удирдах зөвлөл нь Мэдээлэл, Арга зүйн хороо; Боловсролын хороо; Мэргэжлийн Хариуцлага, Ёс зүйн хороо; Аудит, Чанарын хяналтын хороо; Гишүүнчлэл, Нэр дэвшүүлэх хороотой байна.

(өөрчлөгдсөн)

7.6.1 Мэргэжлийн хариуцлага, Ёс зүйн хороо нь гишүүдийн ёс зүй зөрчил, мэргэжлийн алдаа дутагдлыг шийдвэрлэх, ёс зүйн дүрмийг боловсруулж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

(өөрчлөгдсөн)

7.6.2 Боловсролын хороо нь анхан шатны болон тасралтгүй боловсролын хөтөлбөрийг боловсруулах, сургалтын жишиг хөтөлбөрийг батлуулж мөрдүүлэх, сургалт явуулах, эрх сунгах сургалтын хөтөлбөрийг боловсруулан, шалгалт авах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

(өөрчлөгдсөн)

7.6.3 Мэдээлэл, Арга зүйн хороо нь ҮОУС-ыг орчуулах, үндэсний стандарт, үнэлгээний холбогдох дүрэм, журам, заавар, аргачлал боловсруулж батлуулах, үнэлгээний холбогдох мэдээллийн сан бүрдүүлэх, гишүүдийг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

(өөрчлөгдсөн)

7.6.4 Аудит, Чанарын хяналтын хороо нь удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд үнэлэлт өгөх, институтийн үйл ажиллагааны талаар удирдах зөвлөлийн баталсан чиг үүргийг гүйцэтгэх удирдлага хэрхэн хэрэгжүүлэн ажиллаж байгаад хяналт тавьж, зөвлөгөө өгөх, гишүүн үнэлгээчдийн болон үнэлгээний компаниудын үйл ажиллагаанд чанарын хяналт тавих ажлыг зохион байгуулах, институтийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих удирдах зөвлөлийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

(өөрчлөгдсөн)

ТӨСӨЛ

7.6.5 Гишүүнчлэл, Нэр дэвшүүлэх хороо нь гишүүдийн бүртгэл, судалгаа, гишүүдийн үйлчилгээ, сонгуульд нэр дэвшүүлэх, гишүүнчлэлийн үүргийн биелэлтийг хянах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

(өөрчлөгдсөн)

Найм. Институтийн эрх барих байгууллага

8.1 Институтийн эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байна.

8.2 Бүх гишүүдийн Их хурлыг 4 жилд нэг удаа, Ээлжит хурлыг жил тутамд хуралдуулна.

(өөрчлөгдсөн)

8.3 Бүх гишүүдийн Их хурал болон Ээлжит хурал нь гишүүдийн ердийн олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно.

(өөрчлөгдсөн)

8.4 Ээлжит бус хурлыг удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр эсвэл бүх гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар зарлан хуралдуулж болно. Ээлжит бус хурлын зохион байгуулалтын зардлыг зарлан хуралдуулсан этгээд хариуцна.

(өөрчлөгдсөн)

8.5 Бүх гишүүдийн хурлын товыг удирдах зөвлөл тогтооно.

8.6 Бүх гишүүдийн хурлаар дараах асуудлыг шийдвэрлэнэ:

8.6.1 Институтийн болон үнэлгээчдийн ёс зүйн дүрэм, түүнд оруулах нэмэлт өөрчлөлт, институтийн удирдлага, зохион байгуулалтын асуудлыг их хурлаар;

8.6.2 Институтийн удирдах зөвлөл, хороодын бүрэлдэхүүнийг сонгож батлах асуудлыг ээлжит хурлаар;

8.6.3 Институтийн удирдах зөвлөлийн болон хороодын тайланг хэлэлцэж батлах асуудлыг их хурал, ээлжит хурлаар;

8.7 Бүх гишүүдийн хурлын чөлөөт цагт Институтийн бүрэн эрхийг Удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

8.8 Удирдах зөвлөлийг сонгох:

8.8.1. Удирдах зөвлөлийг 4 жилийн хугацаатай 15 /арван таван/ хүний бүрэлдэхүүнтэйгээр бүх гишүүдийн хурлаас нууцаар санал хурааж сонгоно.

8.8.2. Удирдах Зөвлөлийн гишүүдийн 1/3-ийг жилийн тутмын ээлжит хурлаар шинэчлэн сонгож болно.

8.8.3 Удирдах зөвлөлөөс чөлөөлөгдөх гишүүдийн асуудлыг гишүүдийн өөрийн хүсэлт, үйл ажиллагаанд оролцсон байдлыг дүгнэсэн хорооны саналыг харгалзан шийдвэрлэнэ.

(өөрчлөгдсөн)

8.9 Удирдах зөвлөлийн гишүүдийг гишүүн үнэлгээчдийн хороо эсвэл ажил эрхлэлтийн төлөөллийг харгалзан тус бүрийн тогтоосон квотод багтаан сонгоно.

ТӨСӨЛ

(өөрчлөгдсөн)

8.10 Институтийн удирдах зөвлөлийн болон хороодын ажиллах журмыг удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж батална.

8.11 Удирдах зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагааны оролцоог хангах зорилгоор удирдах зөвлөлийн гишүүн хоёр хороонд давхар ажиллаж болно.

(хасагдсан)

8.12 Институтийн тэргүүнийг 4 жилийн хугацаагаар удирдах зөвлөлөөс сонгоно.

8.13 Институтийн тэргүүн нь Удирдах зөвлөлийг тэргүүлж, хуралдааныг даргална.

8.14 Удирдах зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.

8.15 Гишүүдийн олонхи оролцсон үед удирдах зөвлөлийн хурлыг хүчин төгөлдөр гэж үзнэ. Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлаар ил санал хурааж олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Хувь хүний эрх ашигтай холбогдсон асуудлыг нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.

8.16 Удирдах зөвлөлийн гишүүн хүндэтгэх шалтгаанаар хуралд оролцож чадахгүйд хүрвэл тухайн хурлаар хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцаж, саналаа бичгээр ирүүлж болно. Энэ саналыг санал хураалтын тоонд оруулна.

8.17 Удирдах зөвлөлийн хурлаас тогтоол гаргах бөгөөд институтийн тэргүүн гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно. Удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлнө.

8.18 Удирдах зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэх асуудлаар гишүүн сонирхлын зөрчилтэй байвал тухайн гишүүн энэ тухайгаа тайлбарлаж санал хураалтад оролцохгүй.

8.19 Удирдах зөвлөлийн хуралдаан даргалагч тухайн асуудлаар сонирхлын зөрчилтэй байвал хуралдааныг өөр гишүүн даргална.

8.20 Институт нь дэд тэргүүнтэй байж болно. Дэд тэргүүнийг удирдах зөвлөлийн гишүүдээс сонгох ба тэргүүнийг эзгүйд түүний даалгасанаар үүргийг нь хэрэгжүүлнэ.

8.21 Удирдах зөвлөл дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

8.21.1 Институтийн үйл ажиллагааны бодлого, зорилтыг тодорхойлох;

8.21.2 Гишүүний мэргэжлийн эрх ашгийг хамгаалах, Үнэлгээчдийн сонгон шалгаруулалт, тэдэнд мэргэжлийн зэрэг дэв олгуулах асуудлаар ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, санал дүгнэлт гарган төрийн захиргааны байгууллагад оруулах;

8.21.3 Орон нутагт төлөөлөгчийн газар (салбар) байгуулах, түүний ажиллах журмыг батлах;

ТӨСӨЛ

8.21.4 Институтийн тэргүүний санал болгосноор институтийн гүйцэтгэх захирлыг томилох, мэргэжлийн зөвлөл, сонгон шалгаруулалтын хорооны бүрэлдэхүүнд институтээс орох төлөөллийг санал болгох;

8.21.5 Институтийн орон тоо, төсөв, жилийн санхүүгийн тайлан, төсвийн биелэлтийг хэлэлцэж батлах;

8.21.6 Институтийн шагнал бий болгох, олгох, нэр дэвшүүлэх журмыг батлах;

8.21.7 Үнэлгээний үйл ажиллагаанд холбогдох дотоод стандарт, дүрэм заавар, аргачлал, журмыг хэлэлцэн батлаж мөрдүүлэх;

8.21.8 Үнэлгээний мэргэжлийн байгууллагын чадавхийг хөгжүүлэх төсөл, судалгааны ажлын чиглэлийг хэлэлцэн батлах;

8.21.9 **Шаардлагатай** бол Ёс зүйн хорооны гаргасан дүгнэлтийг хэлэлцэж, батлах;
(өөрчлөгдсөн)

8.21.10 Бүх гишүүдийн хурлын бүрэн эрхэд хамаарах **Институтийн бүтцийн өөрчлөлтөөс бусад зарим асуудлаар** шаардлагатай үед шийдвэр гаргаж болно;
(өөрчлөгдсөн)

8.21.11 Удирдах зөвлөл ажлаа бүх гишүүдийн хуралд тайлагнана.

8.22 Бүх гишүүдийн хурлаас сонгогдсон Удирдах зөвлөлийн гишүүд өөр ажилд шилжих болон бусад шалтгаанаар гарвал нууц санал хураалтаар авсан саналыг үндэслэн дараагийн хүнийг нөхөн оруулна.

Ес. Институтийн тэргүүн

9.1 Институтийн тэргүүн дараах үүрэг, эрхтэй байна. Үүнд:

9.1.1 Энэхүү дүрмийн гуравдугаар зүйлд заасан институтийн үйл ажиллагааны чиглэл, үүргийг хэрэгжүүлэхэд хамтын удирдлагаар хангах;

9.1.2 Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулах, даргалах;

9.1.3 Удирдах зөвлөлийн шийдвэрлэсэн асуудлаар гаргасан тогтоолтой танилцаж, гарын үсэг зурж баталгаажуулах;

9.1.4 Институтийн гүйцэтгэх захирлыг томилуулах саналыг удирдах зөвлөлд оруулах;

9.1.5 Удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах;

9.1.6 Удирдах зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг хэлэлцүүлж, батлуулах;

9.2 Институтийг төлөөлөх, төлөөлөх зарим эрхээ шилжүүлэх, гадаад, дотоодын байгууллагатай харилцах, гэрээ, хэлэлцээр байгуулах

Арав. Институтийн гүйцэтгэх удирдлага

ТӨСӨЛ

10.1 Институтийн гүйцэтгэх удирдлагыг сонгоход хөрөнгийн үнэлгээний компаниудаас хараат бус байх зарчмыг баримтлах бөгөөд гүйцэтгэх захиралд нэр дэвшигч нь удирдан зохион байгуулах ур чадвартай, уг ажлыг гүйцэтгэхэд харшлах шалтгаангүй байна.

10.2 Институт нь өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах ажлын албатай байна.

10.3 Ажлын албаны орон тоо, төсвийг институтийн санхүүгийн хүчин чадлыг харгалзан удирдах зөвлөл тогтооно.

10.4 Гүйцэтгэх захирал ажлын албаны үйл ажиллагааг удирдлагаар хангана.

10.5 Гүйцэтгэх захирал дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

10.5.1 Мэргэжлийн хороодын дотоод ажлын албаны орон тооны ажилтныг томилох, ажлын албадын орон тоо төсвийн саналыг удирдах зөвлөлд оруулах;

10.5.2 Институтийн дотоод ажлын албадуудын ажил үүргийн хуваарийг баталж мөрдүүлэх, тэдгээрийн ажлыг уялдуулах, зохион байгуулалтаар хангаж ажиллах;

10.5.3 Гишүүдийн эрх ашигтай холбогдсон асуудлаар төрийн байгууллага, холбогдох газруудад санал оруулж, шийдвэрлүүлэх;

10.5.4 Үнэлгээчин, үнэлгээний мэргэжлийн байгууллагын мэргэжлийн ур чадвар, гишүүдийн ёс зүйн талаар гарсан гомдол, маргааныг холбогдох зөвлөл, хороогоор хянан шийдвэрлүүлэх, тэдгээрийн гаргасан дүгнэлт саналыг удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах болон холбогдох байгууллагад хүргүүлэх;

10.5.5 Үнэлгээний мэргэжлийн байгууллагын чадавхийг хөгжүүлэх төсөл санаачлан боловсруулах, салбарын судалгааны ажлыг нэгдсэн удирдлагаар хангах;

10.5.6 Мэргэжлийн хороодоор дамжуулж үнэлгээний стандарт, аргачлал, журмын төсөл боловсруулах, төсөлд санал өгөх, салбарын судалгааны ажлын чиглэлийг тогтоох;

10.5.7 Гишүүд ёс зүйн дүрмийг хэрхэн сахин биелүүлж байгаа талаар дүгнэлт гаргуулахаар санал оруулах;

10.5.8 Удирдах зөвлөлийн хурлын бэлтгэлийг ханган, цаг үеийн шаардлагатай асуудлуудыг удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

10.5.9 Институтийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбогдсон мөнгөн болон мөнгөн бус орлого, зарлагын гүйлгээг удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд батлагдсан төсвийн дагуу зарцуулах;

10.5.10 Гишүүдийн үйл ажиллагааны жил тутмын тайланг гаргуулан авч, нэгдсэн судалгаа хийх, үнэлгээний мэдээллийн санг бүрдүүлэн гишүүдэд үйлчлэх;

10.5.11 Гишүүдийн мэргэжлийг дээшлүүлэх, тэднийг гадаад дотоодын сургалт, төсөлд хамруулах, туршлага судлуулах, ивээн тэтгэгчдийг олж түншлэх;

ТӨСӨЛ

10.5.12 Институтийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг жилээр гаргаж, дүнг удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулах

Арван нэг. Санхүүжилт, тайлан тооцоо

11.1 Институт өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар үйл ажиллагаагаа явуулах ба санхүүгийн дараах эх үүсвэртэй байна. Үүнд:

11.1.1 Элсэлтийн болон гишүүний татвар хураамж;

11.1.2 Дэмжигчид, ивээн тэтгэгчдийн хандив, тусламж;

11.1.3 Дүрмийн зорилтоо хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаанаас олсон орлого;

11.1.4 Хуулиар зөвшөөрөгдсөн бусад орлого;

11.2 Институтийн хөрөнгийг энэ дүрмээр заагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт болон урсгал зардлыг санхүүжүүлэхэд төсөвлөн зарцуулна.

11.3 Институтийн санхүүгийн тайланг гүйцэтгэх удирдлагаас хариуцан зохих журмын дагуу улирал жилээр гарган, холбогдох газруудад тушааж, татвар, шимтгэлийн тооцоог хийж баталгаажуулах;

Арван хоёр. Институтийн хүлээх хариуцлага

12.1 Институт нь өөрийн үйл ажиллагаанаас бий болох үр дагаврыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хариуцна.

12.2 Институтийг үүсгэн байгуулагч нь институтийн үүргийг хариуцахгүй бөгөөд үүсгэн байгуулагчийн хүлээх үүргийг институт хариуцахгүй.

12.3 Институт нь гишүүд дэмжигчдийн үйл ажиллагаатай холбогдсон үүргийг хариуцахгүй.

12.4 Институт нь түүний нэрийн өмнөөс үйл ажиллагаагаа явуулдаг, хуулийн этгээдийн эрхгүй төлөөлөгчийн газрын үүргийг өөрт холбогдох хэсгээр хариуцна.

12.5 Институтийн гишүүдийн хүлээх хариуцлага

12.5.1 Институтийн гишүүд нь өөрийн үйл ажиллагаатай холбогдсон үр дагаврыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу өөрөө бие даан хариуцна.

12.5.2 Институтийн гишүүд нь институтийн үйл ажиллагаанаас бий болсон үр дагаврыг хариуцахгүй.

12.6 Институтийн ажиллах хугацаа, татан буулгах

12.6.1 Институт үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

12.6.2 Институтийг татан буулгах, өөрчлөн байгуулах асуудлыг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

ТӨСӨЛ

12.6.3 Институтийг татан буулгасан бол эзэмшиж байсан хөрөнгийг түүнтэй ижил зорилго бүхий шинээр үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд уламжлан эзэмшинэ.

Арван гурав. Бусад зүйл

13.1 Энэ дүрмийг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.